НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр Дугаар А/09 Улаанбаатар хот

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.12 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд 11 аймгийн 30 суманд шүлхий, бог малын мялзан өвчин, хонины цэцэг өвчин мөн Нийслэлийн Хан-Уул, Багануур дүүрэгт Бог малын мялзан, дүүрэгтэй хил залгаа Төв аймгийн Баян суманд Бог малын мялзан, Төв аймгийн Баянчандмань суманд Хонины цэцэг өвчин бүртгэгдэн хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан халдварт өвчин дүүргийн нутаг дэвсгэрт дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өөр аймаг сумд руу оторлож буй айл өрхөөс бусад тохиолдолд халдварт өвчин батлагдсан орон нутгаас ирэх үржлийн болон отор нүүдлийн зориулалттай мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг тухайн орон нутгийн хорио цээр, хязгаарлалтын дэглэм татан буугдах хүртэлх хугацаанд хориглосугай.

2.Малчдад гоц халдварт, халдварт өвчний талаар мэдээлэл өгөх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулан, мал эмнэлгийн гэрчилгээгүй амьд мал тээвэрлэсэн, тууварласан тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллахыг хороод (Н.Нямзав, Б.Батзориг), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх), Хөдөө аж ахуйн тасаг (М.Түвшинтөгс)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

11230000037

Adil\2023 онжилт\захирамж